Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Үндэсний хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч, Ганбат Оюун-Эрдэнэ

## 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3.1. Зорилт 8.1. Үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ. | | | | | | | |
| 1 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Явцын тайлангийн тоо /тоо/ | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 01/1565 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2024 оны явцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. /1 тайлан/ | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1961 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн. | 8-р сар, 9-р сар | 100% |
| 2 | Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ | Тайлангийн тоо /тоо | Шинэ сэргэлтийн бодлогын 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, | Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, | Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар | 7-р сар, 8-р сар, 9-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | | үнэлгээ хийж, 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 01/1510 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. /1 тайлан/ | батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 сэргэлтийн бодлогын хүрээнд 29 зорилт, 103 үйл ажиллагааны 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 01/1615 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр дунджаар 56.5 хувьтай гарч, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3.3-т заасны дагуу "зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай" гэж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үнэлэгдсэн. | | |
| 3 | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Тайлангийн тоо /тоо/Тайлангийн тоо /тоо/с | Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/75 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | - | Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2023 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/104 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж тайлагнасан. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2023 оны хэрэгжилтэд хамаарах 47 зорилтын хүрээнд 243 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр баталснаас 243 арга хэмжээний тайлан, шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 2023 оны явцын дундаж үнэлгээ 80.4 хувийн биелэлттэй гарсан. Нийт 94 шалгуур үзүүлэлтийг үндсэн хэрэгжүүлэх 25 байгууллагаас явцын | 1-р сар, 2-р сар, 3-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайланг ирүүлэхээс 14 байгууллага 78 шалгуур үзүүлэлтийн 2023 оны явцын тайланг ирүүлсэн. Үүнээс 13 шалгуур үзүүлэлтийг тайлагнах хугацаа болоогүй, 3 шалгуур үзүүлэлтийг үнэлэх боломжгүй буюу тооцох аргачлал тодорхойгүй тул 62 шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дунджаар 52.8 хувьтай үнэлэгдлээ. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 67 арга хэмжээнд хамаарах зарим үйл ажиллагааны санхүүжилт хийгдсэн бөгөөд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн хувьд улсын төсвөөс 3,130.9 тэрбум төгрөгөөр 39 арга хэмжээ, гадаадын зээл, тусламжаас 1,634.6 тэрбум төгрөгөөр 12 арга хэмжээ, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4,878.7 тэрбум төгрөгөөр 3 арга хэмжээ, Засгийн газрын тусгай сангаас 1,755.5 тэрбум | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгөөр 7 арга хэмжээ, бусад эх үүсвэрээр 68.6 тэрбум төгрөгөөр 6 арга хэмжээ тус тус санхүүжигдсэн байна. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 2023 оны хэрэгжилтийг Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 5 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. | | |
| 4 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | Тайлангийн тоо /тоо/ | Яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний 2023 оны эхний хагас жилийн болон жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн. Сар бүрийн хэрэгжилтийг цахим системээр тайлагнасан. | Яамны эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн болон 2024 оны хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны 1-6 дугаар сарын хэрэгжилтийг яамны дотоод бүтцийн нэгжүүдээс авч Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд сар бүр тайлагнасан. Хөтөлбөрт туссан 17 арга хэмжээний 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 06-р сарын 27-ны өдрийн 03/1263 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үндсэн хэрэгжүүлэх нийт 10 зорилт, 17 арга хэмжээнээс 8 зорилт, 14 арга хэмжээ "үр дүнтэй" буюу 100.0 хувийн хэрэгжилттэй, 2 зорилт, 3 арга хэмжээ "тодорхой үр дүнд хүрсэн" буюу 70.0-92.0 хувийн хэрэгжилттэй байна. Нийт дундаж үнэлгээ 95.8 хувьтай байна. | | |
| 5 | Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, | Тайлангийн тоо /тоо/ | Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, | - | Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2023 оны | 1-р сар, 2-р сар, 3-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | | үнэлгээ хийж, 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/75 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | | жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/104 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд батлагдсан нийт 150 төсөл, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2023 оны хэрэгжилт дунджаар 63.3 хувьтай байна. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 150 төсөл, арга хэмжээнд 2023 онд нийт төсөвт өртгийн 21.7 хувь буюу 10.7 их наяд төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн байна. Нийт 72 төсөлд 2.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 29.1 хувийг улсын төсвийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөрөнгөөр, 60.8 хувийг гадаад зээл, тусламжаар, 3.2 хувийг улсын төсөв болон гадаадын зээл, тусламж хосолсон эх үүсвэрээр, 6.9 хувийг концессын эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна. Энэ нь батлагдсан нийт төсөвт өртгийн 4.6 хувийг эзэлж байна. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" болон "Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн 2023 оны хэрэгжилтийг Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 5 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. | | |
| 6 | Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт- | Тайлангийн тоо /тоо/ | Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд | - | "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн материалыг нэгтгэн "Бодлогын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | | хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. /2 тайлан/ | | баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, танилцуулга, холбогдох тайлангийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/105 тоот албан бичгээр хүргүүлж тайлагнасан. "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-нд 5 бүлэг, 18 зорилго бүхий нийт 75 төсөл, арга хэмжээ, 201 шалгуур үзүүлэлт тусгагдсанаас 2023 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 79.2 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг боловсруулж 2024 оны 06-р сарын 24-ны өдрийн 03/1263 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. "Монгол | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-нд 8 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 194 төсөл, арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлт тусгагдсан. Тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 23 үндсэн зорилтын хэрэгжилт 60.2 хувийн биелэлттэй, 194 төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 40.8 хувийн биелэлттэй үнэлэгдсэн. | | |
| 7 | Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Тайлангийн тоо /тоо/ | - | Яамны эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. /1 тайлан/ | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 12 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 03/1263 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 8 | Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтэд хяналт- | Тайлангийн тоо /тоо/ | Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2022 оны | - | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь | 1-р сар, 2-р сар, 3-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/377 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | | заалтыг үндэслэн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.7.1 дэх заалтыг баримтлан бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, 2024 оны 3 дугаар сарын 15-ны 01/528 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. "Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2023 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 86.1 хувийн биелэлттэй гарсан бөгөөд нийт 21 аймаг болон нийслэлийн хэмжээнд 95.4 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлэгдсэн бол 4.5 хувь нь шалгуур | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн. Аймаг, нийслэлийн дундаж үнэлгээг гаргахад Дорнод 75.8 хувь, Сүхбаатар 76.7 хувь, Архангай 77.2 хувь, Өмнөговь 82.3 хувь, Говь-Алтай 83.9 хувь, Хөвсгөл 86.2 хувь, Дорноговь 86.7 хувь, Дундговь 87.1 хувь, Өвөрхангай 87.9 хувь, Баянхонгор 88.1 хувь, Булган 88.7 хувь, Ховд 88.9 хувь, Говь-сүмбэр 89.6 хувь, Увс 89.8 хувь, Орхон 89.8 хувь, Баян-Өлгий 90.3 хувь, Төв 90.8 хувь, Сэлэнгэ 91.6 хувь, Хэнтий 92.8 хувь, Дархан-Уул 95.1 хувь, Нийслэл 90.5 хувийн хэрэгжилттэй буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн. | | |
| 9 | Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад хөгжлийн зорилго, зорилтын шалгуур | Тайлангийн тоо /тоо/ | Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2023 онд байгуулах гэрээний төсөл болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийн шалгуур | - | Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2023 онд байгуулах гэрээний төсөл болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл, Засгийн газрын 2024-2028 оны үйл | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | | үзүүлэлтэд санал өгсөн. | | ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд санал өгсөн. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тодорхойлохдоо богино хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр тухайн жилд үр дүн нь гарах үзүүлэлт байхаар тодорхойлох талаар Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газарт санал хүргүүлсэн. | | |
| 10 | Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, | Тайлангийн тоо /тоо/ | - | - | Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн 2024 оны | 4-р сар, 5-р сар, 6-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийнэ. | | | | 1 дүгээр улирлын мэдээллийг ирүүлэхийг яамны дотоод бүтцийн нэгжүүдэд 2024.05.20-ны өдрийн 76 дугаартай дотоод бичгээр мэдэгдсэн. Хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн ба тайланг яамны удирдлагад 2024.06.07-ны өдөр танилцуулсан. Бүс орон нутгийн хөгжлийн газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас бусад 6 газрын хувьд хэрэгжилтийн мэдээллийг ирүүлсэнд ХШҮ хийхэд 1/Улсын төсвийн хөрөнгийн хөрөнгөөр санхүүжиж буй 19 төсөл арга хэмжээ – 58.1%, 2/Гадаадын зээл, тусламжаар санхүүжиж буй 4 төсөл – 49.2%, 3/Төр, хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжиж буй 10 төсөл – 41.0% ба нийт дундаж үнэлгээ 51.9% гэж үнэлэгдсэн. | | |
| 11 | Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн | Тайлангийн тоо /тоо/ | - | - | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт | 1-р сар, 2-р сар, 3-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. | | | | бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.6.6-т "Захиргааны байгууллага нь гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ." гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх" төслийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2024 оны 02 дугаар сарын 29-ны 01/438 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн. Тайлант хугацаанд төслийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаснаар нийт 3 бүрэлдэхүүн хэсгийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд 16 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 10 үйл ажиллагааг хэрэгжүүлж 6 үйл ажиллагаа удааширсан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 55.6 хувьтай буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн бөгөөд төслийн ерөнхий хэрэгжилтийн явц 4.7 хувьтай байна. | | |
| 12 | Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ | Тайлангийн тоо /тоо/ | Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2022 оны гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр холбогдох газарт хүргүүлсэн. | - | Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах 2024 оны гэрээний төсөлд 3 дугаар хавсралтад тусгагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшнийг оновчтой тодорхойлж тусгах, арга хэмжээг тодорхойлохдоо 2023 оны гэрээний хэрэгжилтийн үр дүнд үндэслэх, Монгол | 1-р сар, 2-р сар, 3-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор 2024 оны “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээний төсөлд тусгах зэрэг саналыг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газарт хүргүүлсэн. | | |
| 13 | Байгууллагын 2023 оны ил тод байдлын үнэлгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Тайлангийн тоо | Байгууллагын 2022 оны ил тод байдлын үнэлгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлсэн. | - | Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 01/437 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын ил тод байдал 99.2 хувьтай үнэлэгдсэн. Яамны чиг үүргийн хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх 10 хууль, нийтлэг мөрдөх 10 хууль, бодлогын баримт бичгүүд болон холбогдох хууль | 1-р сар, 2-р сар, 3-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоомжийг яамны цахим хуудаст нээлттэй байршуулсан. Албан хаагчийг сонгон шалгаруулах журам, сул орон тооны зарыг хүний нөөцийн ил тод үйл ажиллагаа хэсэгт байршуулсан. Засгийн газрын мэдээллийн цахим сангаар нийт албан хаагчид гүйцэтгэлийн тайланг оруулж, нэгжийн дарга нар үнэлгээг баталгаажуулсан байна. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг нэгтгэн, хянан үзэж, Засгийн газрын хуралдаанд 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр танилцуулсан. Тус тайлангаар Эдийн засаг, хөгжлийн яаманд 5 зөвлөмж өгсөний дагуу яамны 2024 оны эхний хагас жилийн мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилтэд ХШҮ хийж, 2024-11-05-ны өдрийн 03/2356 тоот албан бичгээр ЗГХХГ-т хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилт 99.4 хувьтай үнэлэгдсэн байна. | | |
| 14 | Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | Тайлангийн тоо /тоо/ | Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02/301 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | - | Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 01/437 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 97.7 хувьтай үнэлэгдсэн ба яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн "Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай" А/143 дугаар тушаалаар тайлант онд 15 зорилтын хүрээнд 143 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 117, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90 хувийн хэрэгжилттэй 22, 70 хувийн хэрэгжилттэй 4 | 1-р сар, 2-р сар, 3-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | арга хэмжээ байсан байна. | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байх. | Сургалтад хамрагдсан байх. | - | 100 хувь | Удирдлагын академиас зохион байгуулдаг ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Хариуцсан ажлын чиг үүрэгт хамаарах сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх. | Хариуцсан ажлын чиг үүрэгт хамаарах сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон байх. | - | 100 хувь | ЗГХХГ, УИХ-ын тамгын газраас зохион байгуулсан "Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ" сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 3 | Монгол бичгийн мэдлэгийн түвшнийг | Сургалтад хамрагдсан байх | - | Сургалтад хамрагдаж Монгол бичгээр албан бичиг боловсруулах | Төрийн захиргааны удирдлагын газраас зохион байгуулсан монгол бичгийн | 5-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дээшлүүлсэн байх | | | чадвартай болсон байх /100 хувь/ | сургалтад хамрагдсан. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Үндэсний хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч, Ганбат Оюун-Эрдэнэ

/Г. Оюун-Эрдэнэ............/ Огноо: 2024-12-18